



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 13/47

Улаан-Уул

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө  
оруулалтаар хийгдсэн хөрөнгөд эзэмшигч  
тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 13 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгөд эзэмшигчийг тогтоох жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, бараа материалын бүртгэлд бүртгэх хөрөнгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын гүйцэтгэл дутуу байгаа нийтийн боловсон бие засах газар байгуулах, хойд гудамд худаг гаргах төслүүдийг ажлын хэсэг хүлээж авсан даруйд хөрөнгийн орлогод авч, эзэмшигч тогтоохыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3. Эзэмшигч тогтоосон хөрөнгийг бүртгэх ажлыг тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлтэй хамтран зохион байгуулахыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат)-д даалгасугай.

4. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэхийг төсөвт байгууллагын нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга (Д.Нарантуяа)-д үүрэг болгосугай.


ДАРГА  С.ГОНГОР



Ёсчилсон 2022 оны 12 сарын 19 ны өдөр

648801067

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит  
13 дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний  
өдрийн 13/47 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт




ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР  
ХУДАЛДАЖ АВСАН ХӨРӨНГӨД ЭЗЭМШИГЧ  
ТОГТООХ ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Хөрөнгө эзэмшигч
1	Гудамж, хороололд гэрэлтүүлгийн ажил хийх	20,000,000.0	Засаг даргын Тамгын газар
2	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт	19,500,000.0	Засаг даргын Тамгын газар
3	Хог тээврийн машин худалдаж авах	49,900,000.0	Засаг даргын Тамгын газар
4	Шүдний кабинетын тоног төхөөрөмж	3,100,000.0	Эрүүл мэндийн төв
5	Камержуулалт, камер нэмэх	12,500,000.0	Засаг даргын Тамгын газар
6	Зам дагуу гудамжны гэрэлтүүлэг	20,000,000.0	Засаг даргын Тамгын газар
7	Оготно устгалын багаж	3,000,000.0	Засаг даргын Тамгын газар
8	Шийрийн шандны гар худаг	3,400,500.0	Засаг даргын Тамгын газар
9	Сахалтын гар худаг	5,099,500.0	Засаг даргын Тамгын газар
10	Хавхаастайн гар худаг	3,400,500.0	Засаг даргын Тамгын газар
11	4 дүгээр багийн төвийн дээврийн засвар	6,100,000.0	Засаг даргын Тамгын газар
Нийт дүн		<b>146,00,500.00</b>	

---oOo---

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит  
13 дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний  
өдрийн 13/47 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



БАРАА МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ  
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Хөрөнгө эзэмшигч
1	Ногоон тэжээл	7,520,000.0	ЗДТГ
2	Хивэг, тэжээл	15,200,000.0	ЗДТГ
3	Нарийн ногоон өвс	19,951,500.0	ЗДТГ
	Нийт дүн	<b>42,671,500.00</b>	

---oOo---